## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

## Орхон аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

**Аудитын код: ОРА-2025/86/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Эрдэнэт хот<br>2025 он | Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва<br>Утас:70353088, Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Буян-Ундрах<br>Утас: 70355805, Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn<br>Аудитор: Б.Азжаргал<br>Утас: 70357955, Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2025.02.24 № 58
танай ____________-ны № ____________-т

ОРХОН АЙМГИЙН ТАТВАРЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭВЭЭНСҮРЭН
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орхон аймгийн Татварын газар нь улсын төсвийн татварын орлогыг 101.1 хувь буюу 249,856,139.4 мянган төгрөг, аймгийн төсвийн орлогыг 101.2 хувь буюу 104,836,419.00 мянган төгрөг, сумын төсвийн орлогыг 101.0 хувь буюу 145,019,720.4 мянган төгрөгөөр тус тус биелүүлж, татварын орлогын төлөвлөгөөг 1.1 хувиар буюу 2,638,893.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн хэрэгжүүлж татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг чанартай зохион байгуулсантай холбогдуулан гаргасан Татварын ерөнхий газрын даргын 2024 оны 12 сарын 26-ний өдрийн А/266, газрын даргын 2024 оны 12 сарын 26-ний өдрийн А/79 дугаар тушаалуудыг үндэслэн нийт албан хаагчдад 72,771.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

тушаалуудыг үндэслэн нийт албан хаагчдад 72,771.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

**Бусад асуудал**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Татварын ерөнхий газрын даргатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг 89.16 хувьтай үнэлсэн байна.

Мөн аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, хэрэгжилтийг 97.5 хувьтай үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 59,490,441.30 | 36,299,830.26 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 16,079,905.00 | 3,023,405.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 16,079,905.00 | 3,023,405.00 |
| 3121 | Төгрөг | 16,079,905.00 | 3,023,405.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 16,079,905.00 | 3,023,405.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 43,410,536.30 | 33,276,425.26 |
| 354 | Хангамжийн материал | 43,410,536.30 | 33,276,425.26 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,710,003.60 | 5,371,153.60 |
| 35420 | Аж ахуйн материал | 34,441,951.22 | 24,993,100.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,740,000.00 | 2,610,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,326,181.48 | 254,871.66 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 192,400.00 | 47,300.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 857,076,034.43 | 1,025,521,432.75 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 857,076,034.43 | 1,025,521,432.75 |
| 392 | Биет хөрөнгө | 756,836,034.43 | 925,281,432.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 522,136,065.00 | 719,967,678.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -71,275,072.76 | -96,066,609.57 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 161,800,000.00 | 161,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -62,375,989.20 | -78,590,199.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 317,013,669.87 | 366,891,905.87 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -156,616,356.90 | -194,014,090.23 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 97,066,400.00 | 84,069,800.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -50,912,681.58 | -38,777,052.20 |
| 393 | Биет бус хөрөнгө | 100,240,000.00 | 100,240,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,430,000.00 | 0.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,430,000.00 | 0.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 100,240,000.00 | 100,240,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 916,566,475.73 | 1,061,821,263.01 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 916,566,475.73 | 1,061,821,263.01 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 916,566,475.73 | 1,061,821,263.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 720,858,474.98 | 720,858,474.98 |
| 51101 | Өмч: - төрийн | 720,858,474.98 | 720,858,474.98 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 180,319,130.75 | 325,573,918.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 242,617,090.56 | 180,319,130.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -62,297,959.81 | 145,254,787.28 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 15,388,870.00 | 15,388,870.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 916,566,475.73 | 1,061,821,263.01 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,021,863,527.08 | 3,263,189,845.66 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 52,709,127.08 | 270,146,743.66 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 52,709,127.08 | 270,146,743.66 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 37,709,127.08 | 270,146,743.66 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 37,709,127.08 | 270,146,743.66 |
| 120009 | Бусад орлого | 15,000,000.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,969,154,400.00 | 2,993,043,102.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,630,244,200.00 | 2,308,288,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,630,244,200.00 | 2,308,288,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 338,910,200.00 | 684,754,902.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 338,910,200.00 | 684,754,902.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,084,161,486.89 | 3,117,743,058.38 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,084,161,486.89 | 3,117,743,058.38 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,872,552,182.57 | 2,675,082,574.11 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,281,311,215.00 | 2,026,478,754.11 |
| 210101 | Үндсэн цалин | 616,375,850.00 | 873,137,212.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 344,376,416.00 | 616,465,326.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 64,230,293.00 | 77,517,520.00 |
| 210104 | Урамшуулал | 256,328,656.00 | 371,947,117.00 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | 0.00 | 87,411,579.11 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 160,027,669.85 | 253,347,526.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 114,309,616.56 | 187,058,321.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,130,725.76 | 17,111,333.51 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 9,279,486.17 | 8,555,816.75 |
| 210204 | Ажилгүйдлын даатгал | 2,210,346.65 | 7,525,602.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,097,494.71 | 33,096,452.45 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,034,978.64 | 17,015,928.88 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 7,614,024.12 | 8,849,305.03 |
| 210302 | Түлш, халаалт | 8,256,549.52 | 5,797,360.22 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,164,405.00 | 2,369,263.63 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 102,635,061.38 | 65,993,771.01 |
| 210401 | Бичиг хэрэг | 65,335,886.00 | 27,342,710.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | 9,426,688.00 | 13,045,440.48 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 6,790,951.38 | 8,019,139.31 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 536,400.00 | 535,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,584,200.00 | 4,840,830.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,960,936.00 | 12,210,051.22 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 26,293,750.00 | 38,357,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,293,750.00 | 38,357,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,454,000.00 | 4,690,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,454,000.00 | 4,690,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 170,187,566.81 | 142,055,079.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 168,193,255.81 | 136,626,144.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 106,920.00 | 302,940.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 226,251.00 | 203,315.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 855,000.00 | 4,076,280.00 |
| 210807 | Газрын төлбөр | 751,800.00 | 751,800.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 10,340.00 | 28,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,607,940.89 | 127,143,414.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,000.00 | 867,100.00 |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх | 7,500,000.00 | 14,891,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 105,067,940.89 | 111,385,114.68 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 211,609,304.32 | 442,660,484.27 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 47,599,803.00 | 344,076,237.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,976,803.00 | 0.00 |
| 213208 | ХОН-т тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 144,059,737.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,623,000.00 | 200,016,500.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 164,009,501.32 | 98,584,247.27 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 164,009,501.32 | 98,584,247.27 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -62,297,959.81 | 145,446,787.28 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 192,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 0.00 | 192,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 0.00 | -192,000.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -62,297,959.81 | 145,254,787.28 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,984,154,400.00 | 3,037,764,542.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 15,000,000.00 | 0.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 15,000,000.00 | 0.00 |
| 120009 | Бусад орлого | 15,000,000.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,969,154,400.00 | 3,037,764,542.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,630,244,200.00 | 2,308,288,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,630,244,200.00 | 2,308,288,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 338,910,200.00 | 729,476,342.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 338,910,200.00 | 729,476,342.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,975,563,900.00 | 3,040,871,142.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,975,563,900.00 | 3,040,871,142.00 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,762,768,095.68 | 2,553,489,217.73 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,281,311,215.00 | 2,026,478,754.11 |
| 210101 | Үндсэн цалин | 616,375,850.00 | 873,137,212.00 |
| 210102 | Нэмэгдэл | 344,376,416.00 | 616,465,326.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 64,230,293.00 | 77,517,520.00 |
| 210104 | Урамшуулал | 256,328,656.00 | 371,947,117.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 87,411,579.11 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 160,027,669.85 | 253,347,526.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 114,309,616.56 | 187,058,321.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,130,725.76 | 17,111,333.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,279,486.17 | 8,555,816.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,210,346.65 | 7,525,602.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,097,494.71 | 33,096,452.45 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,743,182.43 | 17,015,928.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,322,227.91 | 8,849,305.03 |
| 210302 | Түлш, халаалт | 8,256,549.52 | 5,797,360.22 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,164,405.00 | 2,369,263.63 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,849,716.40 | 40,440,229.31 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,539,820.00 | 16,487,490.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,100,000.00 | 10,900,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,673,902.40 | 8,019,139.31 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 536,400.00 | 535,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,999,594.00 | 4,498,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 32,111,200.00 | 43,515,760.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,111,200.00 | 43,515,760.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,454,000.00 | 4,690,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,454,000.00 | 4,690,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 208,143,672.00 | 145,204,999.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 206,159,701.00 | 139,820,944.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 106,920.00 | 302,940.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 226,251.00 | 203,315.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 855,000.00 | 4,060,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 751,800.00 | 751,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,127,440.00 | 22,795,320.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,578,900.00 | 602,920.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,548,540.00 | 22,192,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 212,795,804.32 | 487,381,924.27 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,786,303.00 | 388,797,677.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,976,803.00 | 0.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 171,781,177.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,809,500.00 | 217,016,500.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 164,009,501.32 | 98,584,247.27 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 164,009,501.32 | 98,584,247.27 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 8,590,500.00 | -3,106,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 0.00 | 9,949,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.00 | 9,949,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 9,949,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 0.00 | 9,949,900.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 0.00 | -9,949,900.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 8,590,500.00 | -13,056,500.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 7,489,405.00 | 16,079,905.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 16,079,905.00 | 3,023,405.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,441,716,950.0 | 30,777,740.0 | 485,234,181.1 | 1,957,728,871.1 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,441,716,950.0 | 30,777,740.0 | 485,234,181.1 | 1,957,728,871.1 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | -62,297,959.8 | -62,297,959.8 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 720,858,475.0 | 15,388,870.0 | 180,319,130.8 | 916,566,475.7 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 720,858,475.0 | 15,388,870.0 | 180,319,130.8 | 916,566,475.7 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 720,858,475.0 | 15,388,870.0 | 180,319,130.8 | 916,566,475.7 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 145,254,787.3 | 145,254,787.3 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 720,858,475.0 | 15,388,870.0 | 325,573,918.0 | 1,061,821,263.0 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө. түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 16,079,905.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,308,288,200.00 | 2,243,716,532.51 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,308,288,200.00 | 2,243,716,532.51 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,132,547,000.00 | 2,054,918,855.51 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,758,570,500.00 | 1,698,216,722.00 |
| 210101 | Үндсэн цалин | 854,293,500.00 | 873,137,212.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 381,969,200.00 | 375,614,873.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 80,296,600.00 | 77,517,520.00 |
| 210104 | Урамшуулал | 442,011,200.00 | 371,947,117.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 221,009,000.00 | 211,749,789.63 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 155,399,500.00 | 145,460,584.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,402,300.00 | 17,111,333.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,201,300.00 | 8,555,816.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,201,300.00 | 7,525,602.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,804,600.00 | 33,096,452.45 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,803,100.00 | 17,015,928.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,503,100.00 | 8,849,305.03 |
| 210302 | Түлш, халаалт | 11,442,500.00 | 5,797,360.22 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,857,500.00 | 2,369,263.63 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 22,436,400.00 | 22,435,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,900,000.00 | 4,900,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,200,000.00 | 7,200,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,400,000.00 | 5,400,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 536,400.00 | 535,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,400,000.00 | 4,400,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 31,400,000.00 | 31,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 31,400,000.00 | 31,400,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,710,000.00 | 4,690,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,710,000.00 | 4,690,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 64,618,000.00 | 64,410,115.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,504,000.00 | 63,304,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 107,000.00 | 107,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 211,200.00 | 203,315.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 751,800.00 | 751,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 175,741,200.00 | 188,797,677.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 175,741,200.00 | 188,797,677.00 |
| 213208 | ХОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 171,781,200.00 | 171,781,177.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,960,000.00 | 17,016,500.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,014,727,000.00 | 2,230,660,032.51 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,014,727,000.00 | 2,230,660,032.51 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,014,727,000.00 | 2,230,660,032.51 |
| 88 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 3,023,405.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|
| | | 2023.12.31 | 2024.12.31 |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 338,910,200.0 | 729,476,342.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 338,910,200.0 | 729,476,342.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 314,278,894.3 | 508,520,262.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 99,565,009.0 | 328,262,032.1 |
| 210102 | Нэмэгдэл | 17,225,113.0 | 240,850,453.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0 | 87,411,579.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 82,339,896.0 | 41,597,736.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,311,726.0 | 41,597,736.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,681,218.3 | 18,004,629.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,499,860.0 | 11,587,490.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,900,000.0 | 3,700,000.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 281,358.3 | 98,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 14,625,500.0 | 21,715,760.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 153,012,001.0 | 80,794,884.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 152,157,001.0 | 76,516,944.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0 | 195,940.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 0 | 22,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 855,000.0 | 4,060,000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,087,440.0 | 18,145,220.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,538,900.0 | 952,820.0 |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх | 15,548,540.0 | 17,192,400.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0 | 220,956,079.8 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 21,631,305.8 | 20,956,079.8 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,000,000.0 | 200,000,000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 3,000,000.0 | 200,000,000.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 729,476,342.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 338,910,200.0 | 729,476,342.0 |

**Гурав. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 20,950.9 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 20,950.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

***Залруулсан алдаа:***

2024 оны санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

**5.2 Албан шаардлага**

<u>Илрүүлэлт:</u> Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 20,950.9 мянган

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.3-д "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна", 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

### 5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Орон нутгийн нэмэгдлийг ажилласан цагийн бүртгэлд үндэслэн тооцож олголгүй, тухайн сард ажиллавал зохих нийт цагаар тооцон олгож, зөрүүг дараа сард нь суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Цалин, нэмэгдлийн тооцооллыг үнэн зөв бодитой гүйцэтгэх.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая.төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орхон аймгийн Татварын газар | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орхон аймгийн Татварын газар | 2 | 20.9 | | | 1 | 20.9 | 1 | 0 | - | - | - | - |
| **Дүн** | 2 | 20.9 | | | 1 | 20.9 | 1 | 0 | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| **НИЙТ** | | 1 | 1 | | | 1 | | | |